



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12

E-mail: khentii@audit.gov.mn

2024. 07. 25 № 680

танай -ны № -т

ХЭНТИЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ БАЯН-ОВОО
СҮМҮН МОНГОЛ АРДЫН НАМЫН
ХОРООНД

Г Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Баян-Овоо сумын Монгол ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аudit MNS 6817-1:2020 Төрийн аudit. Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аudit. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аudit. Нийцлийн аudit стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын

• 232420708

хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Баян-Овоо сумын Монгол ардын намын хорооны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцооор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Баян-Овоо сумын Монгол ардын намын хорооны мөрийн хөтөлбөр (6 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Сонгуулийн хороонд.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /Ж.ГАНБААТАР/

ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР /Д.ОЮУНТУЯА/

БОЛОВСРУУЛСАН:
АХЛАХ АУДИТОР /Ц.БИЛЭГСАЙХАН/

АУДИТОР /Ц.ХАТАНБОЛД/



МОНГОЛ
АРДЫН НАМ



МОНГОЛ АРДЫН НАМЫН 2024 ОНЫ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН СОНГУУЛЬД
ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР


2024 он

ХЭНТИЙ АЙМГИЙН БАЯН-ОВОО СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН
2024 ОНЫ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН СОНГУУЛЬД
ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

АГУУЛГА

НЭГ: ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

- 1.1. Орон сууц
- 1.2. Эрүүл мэнд
- 1.3. Боловсрол



ХОЁР: ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

- 2.1. Хөдөө аж ахуй
- 2.2. Аялал жуулчлал
- 2.3. Дэд бүтцийн сүлжээ

ГУРАВ: НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД


ДӨРӨВ: ЗАСАГЛАЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД



НЭГ: ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

1.1. Орон сууц:

- 1.1. Иргэдийн ая тухтай амьдрах орчинг бүрдүүлэхэд хувийн болон нийтийн орон сууцаар хангах ажлыг дэмжин үргэлжлүүлэн ажиллана.
- 1.2. Инженерийн шугам сүлжээнд айл өрх ААНэгжүүдийг үргэлжлүүлэн холбоно.
- 1.3. Зорилтот бүлэг /төрийн албан хаагч, залуу гэр бүл/-д чиглэсэн орон сууцны төслийг хэрэгжүүлж, урьдчилгаа төлбөрийн батлан даалт, ипотекийн зээлийн асуудлыг шийдвэрлэнэ.
- 1.4. Хүүхэд залуучуудын цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтыг сайжруулж, тоглоом, спорт төхөөрөмжийг тоог нэмэгдүүлнэ.



1.2. Эрүүл мэнд:

- 1.5. Хүн амын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэг болон эрт илрүүлэгт байнга хамруулна.
- 1.6. Эрүүл эхээс- Эрүүл хүүхэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.7. Гүрээний нуурын нөхөн сэргээх 2317141297 эмчилгээний байр барьж, эмийн бус эмчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ.
- 1.8. Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг шуурхай чирэгдэлгүй ажиллах нөхцөл боломжоор хангах зорилгоор түргэн тусlamжийн суудлын болон туулах чадвартай авто машинаар парк шинэчлэл хийнэ.
- 1.9. Орон нутагт дутагдалтай байгаа эмч мэргэжилтнийг бэлтгэх бодлогыг тодорхойлж, тэднийг чадавхжуулах, хүний нөөцийн баталгааг ханган зайлшгүй шаардлагатай боловсон хүнийг бэлтгэх зорилгоор “Зөгийн үүр” арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 1.10. Хүн амыг амьдралын зөв дадалд хэвшүүлэх хөтөлбөр боловсруулж сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулна.
- 1.11. Шүдний кабинетийн үйл ажиллагааг тогтмолжуулж, мэргэжлийн боловсон хүчний асуудлыг шийдвэрлэж ажиллана.

1.3. Боловсрол:

- 1.12. Спорт цогцолборын барилгын ажлыг хугацаанд нь ашиглалтанд оруулна.



1.13. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэхэд бүх талаар анхаарч дэлхий, тив, улс, аймаг, бүс, сумын чанартай спортын тэмцээнд оролцоход нь дэмжлэг үзүүлэх, амжилт гаргасан баг тамирчдыг шагнаж урамшуулах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангана.

1.14. Үндэсний спортыг жигд хөгжүүлэхэд холбогдох арга хэмжээг авч ажиллана.

1.15. Сургуулийн өмнөх насны хүүхдүүдийг цэцэрлэгт бүрэн хамруулж багш ажилчдыг чадавхижуулах сургалтанд хамруулна.

1.16. Цэцэрлэгийн гаднах орчин, тоглоомын талбайг шинэчлэн тохижуулна.

1.17. ЕБС-ийн багш, албан хаагчид, суралцагчдад ажиллаж суралцах таатай орчинг бүрдүүлж материаллаг баазаар хангахад анхаарч ажиллана.

1.18. Боловсрол-Нутгийн хөгжил хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэн ажиллана.

1.19. Малчдын хүүхдүүдийг дотуур байранд бүрэн хамруулна.

1.20. ЕБС-ийн хичээлийн шал, дээврийн засварын асуудлыг шийдвэрлүүлнэ.

1.21. Хүүхэд-Хөгжил хөдөлмөр зуслангийн үйл ажиллагааг эхлүүлж, тохижилтын ажлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.

1.22. Элсэлтийн өрөнхий шалгалтын оноогоор тэргүүлсэн болон чухал шаардлагатай мэргэжлээр суралцаж байгаа оюутан суралцагсадтай хамтран ажиллах гэрээ байгуулж, тэтгэлэгт болон бусад хөтөлбөрүүдэд хамруулна.

1.23. “Оюунлаг Баян-Овоочууд”, “Оюуны хөтөч багш” дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажиллана.

1.24. Соёлын төвийн албан хаагчдыг мэргэжилтэй боловсон хүчинээр хангах, мөн мэргэжил дээшлүүлэхэд нь анхаарч ажиллана.

1.25. Орон нутгийн судлах танхимиын үзмэрийг баяжуулна.

1.26. Түүхэн дурсгалт газруудыг аймгийн аялал жуулчлалын маршрутаар холбоно.

ХОЁР: ЭДИЙН ЗАСГИЙН ЕОДЛОГЫН ХҮРЭЭНД

2.1. Хөдөө аж ахуй:

2.1. Сумын брэнд бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгож “Баян-Овоо брэнд” төслийг Олон Улсын байгууллагатай хамтран шийдвэрлэнэ.

2.2. Малжуулах төслийг хэрэгжүүлж, залуу малчдыг дэмжиж ажиллана.



2.3. Бэлчээрийг зохистой ашиглах, усан хангамжийг нэмэгдүүлж малчдын саналд тулгуурлан худаг гаргах, сэргээн засварлах, булгийн эхийг хашиж хамгаалах зэрэг арга хэмжээнүүдийг шат дараатай авч хэрэгжүүлнэ.


2.4. Мал аж ахуйн түүхий эд, мал нядалгааны бага оврын үйлдвэрийг ашиглалтад оруулна.

2.5. “Малчин миний-Мал эмнэлэг” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана.

2.6. “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” хөтөлбөрийн хүрээнд малчдыг дэмжин ажиллана.

2.7. Бэлчээрийг зохистой ашиглах, малын чанарыг дээшлүүлэх, бэлчээрийн доройтол, цөлжилтийг бууруулах чиглэлээр төсөл, хөтөлбөртэй хамтран ажиллана.

2.8. Хүлэмжийн тариалалтыг нэмэгдүүлж, хөрс боловсруулах, дунд оврын техник, тоног төхөөрөмжөөр хангах, бүтээгдэхүүн хадгалах зоорь барихад дэмжлэг үзүүлнэ.



2.2. Аялал жуулчлал:

2.9. Бүс нутгийн түүхэн аялал жуулчлалын хүрээнд Хубилай хааны төрсөн нутаг болох түүхэн улбагаг судлан тогтоож цогцолбор байгуулах.

2.10. Аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор Эвент арга хэмжээг зохион байгуулна.

2.3. Дэд бүтцийн сүлжээ:

2.11. Багийн төвүүдийг үе шаттайгаар цахилгаан дамжуулах агаарын шугаманд холбоно.

2.12. Дэлгэрхаан, Наран, Сүмбэр багт үүрэн телефоны сүлжээг өргөтгөнө.

2.13. Цаг уурын Баян-Овоо өртөөний барилгыг шинээр барина.

2.14. Баян-Овоо-Түмэнцогт чиглэлийн хатуу хучилттай авто замыг барьж ашиглалтанд оруулна.

ГУРАВ: НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

3.1. “Өрх бүр-Нэг мод” хөдөлгөөнийг жил бүр өрнүүлж ажиллана.

3.2. Төмс, хүнсний ногоо тариалан, чацаргана хөтөлбөрт хамрагдах, хүлэмж болон ногооны бүлэг байгуулах зэрэг оролцооны бүхий л санал санаачилга, бүтээлч ажлуудыг дэмжинэ.



3.3. Бэлчээрийн менежментийн бодлогыг хэрэгжүүлнэ.

3.4. Хоршоо, нөхөрлөлийн хэмжээнд төмс, хүнсний ногооны ажлыг зохион байгуулна.

3.5. "Тэрбум мод" хөтөлбөрийн хүрээнд ОУБ-тай хамтарч 100000 га газрыг ойжуулах арга хэижээг үе шаттайгаар зохион байгуулна.

3.6. "Тохилог орчин-Ногоон хөгжил" дэд хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.

3.7. Аравтын зохион байгуулалттай БНХМ-ийн нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжих "Миний нутаг-Бидний баялаг" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

3.8. Байгаль орчныг хамгаалах асуудалд иргэн бүрийн анхаарлыг хандуулж, байгаль орчноо хайрлан хамгаалах ухамсар мэдлэг олгох, сургалтуудыг зохион байгуулна.

3.9. Сумын төвийн ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн, ногоон зурvasуудыг шинээр байгуулж, ногоон байгууламжуудын ашиглалт, үйлчилгээг сайжруулна.

3.10. Хог хаягдлын цогц менежментийг хэрэгжүүлж, II-р зэргийн ландфил байгууламж бий болгоно.

3.12. Гүрэмийн нуур, аялал жуулчлал, эмчилгээ сувилалыг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллана.

3.13. Сумын төвд шинээр газар эзэмших, өмчлөх эрх авч кадастрын зураглалд орсон газруудад цахилгааны шугам тавих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

3.14. "Манай гудамж-Гэрэлтэй гудамж" төслийг хэрэгжүүлж гэр хорооллын гэрэлтүүлгийг сайжруулах ажлыг жил бүр санхүүжүүлж ажиллах.

ДӨРӨВ: ЗАСАГЛАЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

4.1. Иргэний нээлттэй танхимын үйл ажиллагааг сайжруулан аливаа төсөл хөтөлбөр, тендер сонгон шалгаруулалтыг иргэдэд ил тод, нээлттэй явуулах бодлого баримтална.

4.2. "Орон нутгийн хөгжлийн сан", "Хоршоо хөгжүүлэх сан"-гаас зарцуулагдах хөрөнгөнөөс зээл олгоходо багийн иргэдийн нийтийн хурлаар төслүүдийг хэлэлцэж шийдвэрлэдэг тогтолцоог бий болгоно.

4.3. "Архидалтгүй-Баян-Овоочууд" "Соён гэгээрэл", "Сайн хөрш" дэд хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

4.4. Төрийн ажил үйлчилгээг ил тод, авилгаас ангид хүнд сурталгүй болгож нэг цэгийн үйлчилгээний чанарыг дэвшүүлж, киоск машин байршуулна.



4.5. Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, боловсон хүчнийг бэлтгэх, дэд хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.

4.6. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны нээлттэй тунгалаг байдлыг хангаж, төрийн нууцад хамаарахаас бусад мэдээллийг иргэд чөлөөтэй танилцах боломжийг бүрдүүлж, цахим системийг нэвтрүүлнэ.

4.7. Төсвийн ил тод байдлыг хангаж, сумын төсвөөс зарцуулах хөрөнгийг бүх шатны байгууллагаас иргэдэд мэдээллэх, тайлагнах, “Ил тод төсөв” хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

4.8. Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гарсан хэрэг зөрчлийг илрүүлэхэд дэмжлэг үзүүлж, мал хамгаалах малчдын бүлгийн үйл ажиллагааг идэвхижүүлэх зорилгоор “Хишиг өдөр” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

4.9. Сумын авто замын тэмдэг, тэмдэглэгээг нэмэгдүүлж телекамерийн системийг шинэчлэх, гүүрний хяналтын постыг ажиллуулна.

4.10. Суманд шаардлагатай эмч, багш мэргэжилтэй боловсон хүчинг гурвалсан гэрээний үндсэн дээр ажиллуулах шинэ тогтолцоог бий болгоно.

4.11. “Гамшгаас хамгаалах” дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

4.12. “Иргэдэд үйлчлэх төв”-ийн барилгыг барьж ашиглалтанд оруулна.

4.13. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Бугат хотын Баян-Овоо дүүрэг, ОХУ-ын Өвөр байгалийн хязгаарын Дульдрага аймгийн Зүтгэл тосгон, Өмнөговь аймгийн Баян-Овоо сум, Баянхонгор аймгийн Баян-Овоо сумтай “Баян-Овоочуудын түншлэл” хүрээнд хамтын ажиллагааг үргэлжлүүлнэ.

